

СУМЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Мөрөн сум 1923 онд байгуулагдсан 3400 мянган ам кв газар нутагтай 1922 хүн ам,174828 толгой малтай,2500 га талбайд үр тариа,малын тэжээлийн ургамал,90,1 га талбайд төмс хүнсний ногоо тариалдаг мал аж ахуй-газар тариалангийн бүс нутаг юм.

Газар зүйн байршил:

Улаанбаатар хотоос 313 км,аймгийн төвөөс 27 км зайд байрладаг.218.5 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай,түүний 209,3 мянган га нь бэлчээр,7,4 мянган га нь хадлангийн,0,5 га нь хот суурингийн,0,10 мянган га нь тусгай зориулалтын газар,0,2 мянган га нь тариаланд тохиромжтой талбай,0,6 мянган га нь усны нөөцөд хамрагдаж байна. Урдуураа Баянхутаг,баруунаараа Дэлгэрхаан, хойгуураа Өлзийт тосгонтой,зүүнээрээ Хэрлэн сумдтай тус тус хиллэн 3400 ам км талбай бүхий нутаг дэвсгэрийг эзлэн оршдог.

Байгаль, газарзүйн онцлог:

Далайн төвшнөөс дээш 1600 метр өргөгдсөн,Төв азийн хойд хагас Монголын өргөн уудам нутгийн зүүн хагаст Хэнтийн уулархаг нутгийн шувтрах үзүүр,Хэрлэн голын хойд биеэр нутагтай Мөрөн сум бүхэлдээ тал хээрийн бүсд багтдаг.нутгийн ихэнх нь тал, хөндийн газар юм.Алт,болор,диц,гянт,барилгын материалын баялагтай.Уулсаас эх авсан горхиуд болон гидрокарбонат-кальцийн найрлагатай Дашлингийн рашаан,Хэрлэн,Мөрөн голуудтай.Хээрийн хүрэн,карбонатлаг хар хүрэн,нугын хүрэн хөрс зонхилдог.Хужир мараа ихтэй.Алаг өвс,хиаг,хялгана,жигжиг үетэн,харгана,бут сөөг бүхий хадлан бэлчээрийн нөөц сайтай.Хэрлэн голын хөвөөгөөр бургасан шугуйтай.Тарвага,зурам,хярс мануул,туулай, чоно,үнэг болон хээрийн ба усны шувууд элбэг.Улсын тусгай хамгаалалттай Өндөрхаан уул,Салбар уулын бичигт ханангийн их бага бичээс,Лингийн рашаан,Гэлэн хөшөө,Гамал,баруун,зүүн Хэрэм зэрэг түүхийн дурсгалт,байгалийн үзэсгэлэнт газруудтай.

Цаг уурын нөхцөл:

Тус сумын нутагт жилд 160 мм хур тунадас ордог.Салхины дундаж хурд 4,6 м/с,Агаарын дундаж температур -1+2 градус, хамгийн халуун нь 6-н сард +32,8 градус,хүйтэн нь 12-1 сард -48,2 градус хүрч хүйтэрдэг.

/ЭДИЙН ЗАСАГ/

Эдийн засгийн бүтэц:

12 аж ахуйн нэгж ,4 хоршоо,6 төсвийн байгууллага,2 Төрийн бус байгууллага,4 бүлэг үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөдөө аж ахуй:

Сумын хэмжээгээр нийт 174.828 мянган мал тоологдсоноос цэвэр үүлдэр,эрлийз,нутгийн шилмэл омгийн 12.0 мянган толгой мал тоологдсон нь нийт малын 6.8 хувь байна.286 малчин өрх,110 малтай өрх байгаа нь сумын нийт өрхийн 55,9 хувийг эзэлж байна.

2017 онд төмс 26,5 га талбайд хүнсний ногоо,24,9 га талбайд тэжээлийн ургамал,1,5 га-д эмийн ургамалыг тус тус тариалаад байна.

Малын бүтэц

Сумын хэмжээнд 174828 толгой малтайгаас 436 тэмээ,14712 адуу12243 үхэр,89204 хонь,58233 ямаа байна.

НИЙГЭМ

Хүн ам:Нийт 1922 хүн амтай .Үүнээс эрэгтэй 1040,эмэгтэй 882

Нийгмийн үйлчилгээний барилга, байгууламж:

1	Сургууль	хүүхэд	135
2	Сургуулийн дотуур байр	ор	20
3	Цэцэрлэг	хүүхэд	75
4	Эмнэлэг /хэвтэж эмчлүүлэх/	ор	
5	Соёлын төв	тоо	1
6	Банк	тоо	2
7	Холбооны салбар	тоо	1

ИТХурал:

Ерөнхий Боловсролын Сургууль:

Мөрөн сумын сургууль 1947 онд бичиг үсгийн түр сургууль нэртэйгээр анх байгуулагдаж байсан.Эдүгээ 28 багш ажилчид,132 сурагч, 9 бүлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Монголын орчин үеийн хүүхдийн утга зохиолыг үндэслэгчдийн нэг яруу найрагч,хүүхдийн зохиолч Д.Содномдоржийн нэрэмжит Мөрөн сумын ЕБСургууль түүхт 70 жилийн ойгоо энэ 9-р сард тэмдэглэн өнгөрүүлээ.

Цэцэрлэг:1964 онд байгуулагдсан.2015 онд 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг Улсын төсвийн хөрөнгөөр барьж ашиглалтанд оруулан 13 багш ажилчид,75 хүүхэд,3 бүлэгтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Соёлын төв:

1964 онд анх байгуулагдсан.Одоо 6 орон тоотойгоор ажиллаж байгаа Соёлын төвийн хамт олон нь иргэдэд соёл урлагийн үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд чанартай үйлчлүүлэгсдийн сэтгэл ханамжийн баталгааг хангаж хүргэх зорилготой ажиллаж байна.

Эрүүл Мэндийн төв:

Академич, шинжлэх ухааны Гавьяат зүтгэлтэн, Доктор, Профессор Цэндийн Хайдавын нэрэмжит Мөрөн сумын эрүүл мэндийн төв 19 орон тоотой 5 ортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

ЗДТГазар: ЗДТГазар нийт 32 ажилтан албан хаагчидтай.Иргэдийн оролцоонд тулгуурлан төрийн үйлчилгээг ил тод,шударга,хөнгөн шуурхай нээлттэй хүргэж ажиллах зорилго тавин ажиллаж байна.

Суманд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд:

Сум хөгжүүлэх сан

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан,малжуулах,Тэгш дүүрэн хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

Сумын брэнд бүтээгдэхүүн:

❖ Мөрөн сумын 3-р багийн Аймгын аварга малчин Г.Мягмарбаатарын гэргий Б.Оюунцэцэг "Мөрөн хүнс" ХХК байгуулан үхрийн мах болон дайвар бүтээгдэхүүнийг хатааж савладаг жижиг үйлдвэр байгуулан суманд мах боловсруулах үйлдвэрлэл хөгжих боломжтойг харуулж байна.Тун удахгүй

гадаадад байгаа ахан дүүсдээ Монгол амтыг мэдрүүлэх эрэлт ихтэй брэнд бүтээгдэхүүн болгох зорилттой.

- ❖ Ард түмний гавъяат агрономч Л.Нямаагийн санаачилсан “Мөрөн нутгийн цагаан хальст сармис”-ийг нутгийн ногоочид тариалан Хэнтийн брэнд бүтээгдэхүүн болгосон төдийгүй улсдаа олдоц ховортой эрэлт ихтэй бүтээгдэхүүн юм.Мөрөн цагаан сармис нь аймгийн Брэнд бүтээгдэхүүний шагнал 2 удаа,зүүн бүсийн брэнд шагнал,Алтан намар үзэсгэлэн худалдааны 2,3-р байраа шагнагдаж байсан Шилдэг бүтээгдэхүүн юм.
- ❖ 4-р багийн иргэн Пүрэвийн Бямбадавга Модон эдлэлээр үйлдвэрлэл эрхэлж жилд дунджаар 16,000,0 сая төгрөгийн борлуулалтыг хийж өрхийн орлогоо нэмэгдүүлэн ажиллаж байна.Түүний урласан Морин хуур,гэрийн тавилгууд сум,аймагтаа эрэлт ихтэй бүтээгдэхүүнүүдийн нэг болоод байна.

Харилцаа холбоо:2003 он шилэн кабелд холбогдсноор 2012 оноос бүх албан байгууллагууд интернетэд холбогдож үүрэн холбооны Mobikom.Unitel.G Mobile.Skytel-ийн сүлжээний үйлчилгээг өргөнөөр ашиглаж байна.


Сумын хөшөө,дурсгал:

- ❖ Монголын орчин үеийн хүүхдийн утга зохиолыг үндэслэгчдийн нэг яруу найрагч,хүүхдийн зохиолч Д. Содномдоржийн нэрэмжит хөшөө
Содномдоржийн нэрэмжит хөшөөг ЗДТГ-ын хашаанд талбайд байрлуулан мөнхжүүлсэн.
- ❖ “Монгол алтан хундага” эмийн ургамлын хөшөөт цэцэрлэг.

ТӨРИЙН ШАГНАЛТНУУД:Партизан Базарын Пунцаг,Академич,Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн Цэндийн Хайдав,Гавъяат нэгдэлчин Должингийн Намжил,Гавъяат нэгдэлчин Дэмбэрэлийн Цэрэнням,МУГЖ Дашдэндэвийн Цэрмаа, яруу найрагч,хүүхдийн зохиолч Дамдинцоогийн Содномдорж,МУГЖ Гэндэндарамын Эрдэнэбат,МУГЖ Дамбийнямын Жагдаг,МУГавъяат малчин Намхайн Доржпаа,МУ-ын Хүний Гавъяат эмч Жамбалын Батхуяг,ХАА-н аварга мэргэжилтэн Ламзавын Нямаа,МУ-ын аварга ногоочин Сандагын Оюун-эрдэнэ,Улсын аварга ногоочин Батдэлгэрийн Лхагвадулам,Улсынаварга хоньчин Гунгаажанцангийн Батхишиг,Улсын аварга тууварчин Пунцагын Лувсанцэнд,Хэл шинжлэлийн ухааны доктор Үүрэгийн Ариунболд

Одон орон судлаач зурхайч Чүлтэмийн Жамц,Сийлбэрч Цэдэнгийн Цагаан өвгөн,МУСТАжилтан Хоролын Нямдаваа,МУСТА Сийлбэрч зураач Д.Хуягт,МУСТА зураач,барималч бурханч Намсрайн Шархүү зэрэг олон арван сайчуудтай

МӨРӨН СУМЫН МАЛЫН ТОО,АНГИЛАЛ СҮҮЛИЙН 5 ЖИЛД



	АДУУ	ТЭМЭЭ	ҮХЭР	ХОНЬ	ЯМАА
2012	9514	414	8666	74850	50053
2013	11140	391	9997	79990	53473
2014	11902	412	10599	77782	52939
2015	12710	422	11526	79863	51679
2016	14712	436	12243	89204	58233

БАЙГАЛИЙН БАЯЛАГ, АШИГТ МАЛТМАЛЫН ОРД ГАЗРЫН

ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Хэнтий аймгийн Мөрөн сум нь тал хээрийн бүст оршдог. 2017 оны байдлаар сумын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр ашиглалтын 7 тусгай зөвшөөрөл, хайгуулын 13 тусгай зөвшөөрөл байна. Байгалийн баялагийн хувьд алт, жонш, хүрэн нүүрс зэрэг ашигт малтмал илрээд байна. Үүнээс эдийн засаг стратегийн томоохон ач холбогдол бүхий хүрэн нүүрсний 2 орд илэрч 600 МВт хүчин чадалтай цахилгаан станц баригдахаар төлөвлөж техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдсан. Бэрх-Уул ХХК –ын тогтмол үйл ажиллагаа явуулж Чандганы нүүрсний уурхай нь аймгийн нүүрсний хэрэглээний 90% хувийг ханган ажиллаж байна.


Ургамал, амьтан:

Хээрийн хүрэн, карбонатлаг хар хүрэн, нугын хүрэн хөрс зонхилдог. Ургамлын бүрхэвчийн хувьд уулархаг газруудад шивээт хялгана, хазаар өвс, саман ерхөг, дааган сүүл, навтуул, үхэр тарна, ганга өвс, гол гэсэр, буурцагтнаас үхэр хялгана, хунчир, тэгшивтэр тал хээрийн газруудад түнх хиаг, хазаар өвс, шивээт хялгана, саман ерхөг, хонгор зул, имт гичгэнэ, үхэр тарна, агь, гол гэсэр, шувуун хөл, голын хөндий намхотос газруудад ахар сорт арвай, улаантолгойт, нугын биелэг өвс, даган сүүл% хиаг, бут улалж, ширэг улалж, эмийн сөд өвс зэрэг 200 гаруй бэлчээрийн хэв шинжийн ургамлууд зонхилдог.

Тал хээрийн бүсэд байх бүх ан амьтан бий. Үүнд буга, аргаль, бор гөрөөс, нохой зээх, тарвага, чоно үнэг, хярс, туулай, цагаан зээр зэрэг ан амьтад хун галуу, ангир нугас, тоодог, тогоруу, ятуу, идлэг шонхор, бүргэд, илээ, шар шувуу зэрэг жигүүртэн шувууд байдаг.

МӨРӨН СУМЫН БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Мөрөн сумын брэнд бүтээгдэхүүн “Мөрөн цагаан сармис” нь олон жил найдвартай ургац өгч байгаа чухал төрлийн таримал юм. Сармис нь хамгийн их илчлэгтэй, биеийн эсэргүүцэл сайжруулахаас гадна ханиад, ходоод гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг сайжруулж, үрэвсэлийг анагаах, залуужуулах, тамир тэнхээг ач тустай. Сүүлийн үед ази болон зүүн өмнөд азийн орнууд тухайлбал Солонгосчууд энэ ургамлаас төрөл бүрийн эмийн бодис гарган судалж шинжилж байна. Манай нутгийн Цагаан сармис нь аймгийн брэнд бүтээгдэхүүний шагналыг 2 удаа, зүүн бүсийн брэнд шагнал, Алтан намар үзэсгэлэн худалдааны 2,3-р байр, шилдэг бүтээгдэхүүн “Алтан медаль”-р шагнагдаж байсан шилдэг чанартай бүтээгдэхүүн юм.



“СУМЫН БРЕНД” БҮТЭЭГДЭХҮҮН

1. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 3.2.1.Сумынхаа бусдаас ялгарах онцлог, бахархал, үнэт зүйлийг тодруулан, түүнд үндэслэсэн брэнд бүтээгдэхүүнийг бий болгоно. Үүний тулд 3.2.1.1. Сумынхаа бусдаас ялгарах онцлог, бахархал, үнэт зүйлийг тодруулан, түүнд үндэслэсэн брэнд бүтээгдэхүүнийг бий болгохоор тусган ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд Мөрөн сумандаа үйл ажиллагаа явуулж байгаа 19 иргэд, 1 хоршоог “Цагаан сар цагаан идээ” үзэсгэлэн худалдаанд оролцуулан өөрсдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн бусдаас ямар, хэр түвшинд байгаа цаашид хөгжүүлэх боломж бололцоог судлан үзлээ. Сүү, сүүн бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүн, нөөшилсөн бүтээгдэхүүн, арьс ширэн бүтээгдэхүүн, мод, модон эдлэл, оёмол бүтээгдэхүүн, Төмс, хүнсний ногоо, Эсгий урлал, томсон эдлэл гэсэн 9 төрлөөр оролцож 5,4 сая төгрөгийн борлуулалт хийв. Уг үзэсгэлэнгээс мод, модон эдлэл үйлдвэрлэгч соёлын өв тээгч П.Бямбадагва МХАҮТ-ын “Бүтээлч хүн” медалиар шагнагдаж 1,8 сая төгрөгийн гэрийн тавилгын борлуулалт хийн цаашид хөнгөлөлттэй зээлэнд хамруулах Засаг даргын батламжийг олгосон. Ж.Сэрчмядагын цагаан идээ, Г.Энхцэцгийн бэлтгэсэн айраг эрэлт ихтэй байсан бол Мөрөнгийн цагаан саримс эрэлтэй ихтэй ховор байж сүү, цагаан идээ, гахай, хонь, үхрийн мах илүүтэй борлогдов. Иргэн Ч.Самбуужавын үйлдвэрлэсэн суран эдлэл хөгжүүлж болох үйлдвэрлэл байлаа.



Ахмадууд өөрсдийн үйлдвэрлэлээр манлайлан оролцдог.



“Зах зээл билчээр
удирдлагын менежмент” төсөлд
хамрагдагсад.



Я.Гэрэлт-Одын бэлтгэсэн
цагаан идээ борлуулалт сайн байлаа.



Сүүн далай бүлгийн ахлагч
Ж.Сэржмядаг үзэсгэлэн худалдаанд жил
бүр амжилттай оролцдог. Эрэлт ихтэй
бүтээгдэхүүн



Цагаан сарын хамгийн
сайхан идээ энэ байлаа.



Аймгийн алдарч уяач Цэвээний бэр Г.Энхцэцгийн айраг хамгийн сайхан айраг байж худалдан авагч сэтгэл өндөр байлаа. Шалгаруулах комисс савлагааны асуудлыг шийдвэрлэвэл дэмжих боломжтой бүтээгдэхүүн гэж үнэллээ.

“Морьд хурдан бол айраг сайхан”



Ахмадын бүтээлч үйлсийг дэмжин төсөл хөтөлбөрт хамруулвал үндэсний соёл уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэмэгдэх нь дамжиггүй. Эдэлгээ даах бүтээгдэхүүн.



Сав баглаа боодол, хаяг шогшо нд анхаарал хандуулах нь зүйтэй.





Мөрөнгийн нэг бренд бүтээгдэхүүн- Сийлбэртэй модон эдлэл үйлдвэрлэгч П.Бямбадагва /Бэлэг дурсгэлийг зүйлс, морин хуур, гэрийн модон эдлэл/

2. Мөрөнгийн цагаан сармис бол Мөрөн сумын № 1 бренд



МӨРӨН ЦАГААН САРМИС

*Мөрөн сумын цагаан сармис нь тус суман найдвартай ургац өгч байгаа чухал тари
Сармис нь хамгийн их илчлэгтэй хүний
байгаа илчлэгийг нөхдөг ба биеийн эсэргү
сайжруулахаас гадна төрөл бүрийн хани
гэдэсний өвчин анагаадаг эмчилгээний ач
ургамал юм. Сармисыг янз бүрийн хиам, н
болон лаазалсан зууш бэлтгэхэд найрлаг
амтлаг сайхан чанартай болгодог тул үг
холбогдолтой ургамал юм мөн өвөл хавр
ядарч доройтсон малд нэг ширхэг хумсыг
хандлаад уулгахад хөл нь чангарч бие нь
гэжэ нутгийн сайн малчид үнэлдэг.*



Сармисаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тал дээр түншлэлийн байгууллагуудтай хамтран ажиллаж 11 сард ногоочид -эрдэм шинжилгээний ажилтнуудтай уулзалт-ярилцлагыг “ Хэнтийн ногоочдын сүлжээ” Каритас Чех ,

Жэрэс олон улсын байгууллагын түншлэлийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.

Сармисны үрийн асуудал дээр голлон анхааралаа чиглүүлж байна.

СУМЫН БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН,ТҮҮНИЙ ОНЦЛОГИЙН ТАЛААР /ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ/

Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж эхэлсэн “Мөрөн Хүнс” ХХК-ны үйл ажиллагааг явуулж байна.Хаяг шошго,үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай аймгийн Засаг дарга, ХХААГ, аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалтын газрын холбогдох мэргэжилтнүүд болон Мерси кор ОУБ-тай холбон хамтран ажиллахаар болсон.



To: Buyer: Б.Оюундорж
Мөрөн Хүнс ХХК
Хаяг: Хаягшай, Зүрх
Phone: 99633332, 99698037
Email: oyu@mychina.biz

From: Mychina.biz Hong K
Qianjin street, Xuefu,
Erlan, IM, China
Gap утас: +86-15810
Mobile: 95859000,
director@mychina.biz

Хангамж	Дуг	Бичлэг	Дуг
Ц.Энхтайвны	Завсраг	FOB Erenhot	Wuhan
1	Хатаагч машин 10 тоннтой	14500 юань	14500
1	Олон үйлдэлтэй малын машин	2500 юань	2500
1	Билүү чанар	14900 юань	14900
1	Хянаагч нунтаглагч 3000	4700 юань	4700
1	Тасан цонхтой бар код хяналттай хавтгай хан	1550 юань	1550
1	Хянаагч аргумент	350 юань	350
1	Утасны савтар-аваргч-машин	1400 юань	1400
1	Вакуум савтарч Герман	800 юань	800
1	Мах ногооны нууц бэлтгэгч	2360 юань	2360
1	Дулаан модоор цуас	500 юань	500
1	Дэлгүүрийн гүн хөлдөөгч	4800 юань	4800
20	Бууны тавиур	14 юань	280
1	Олон үйлдэл	1980 юань	1980
3000	10x15 Вакуум уут	0.23 юань	690
1000	12x20 Вакуум уут	0.30 юань	300
1000	15x20 Вакуум уут	0.37 юань	370
1000	30x42 см 924 Махнагч уут	1.88 юань	1880
	Нийт		54480

7-10 хоногт нийлүүлнэ.
Our Bank Information
Ханг банкны дансны дугаар: 5220012861
Ханг: 364.9 х 54480 юань = 19879000 төгрөг
Хүлээн авагч: Төмөр-Очирын Сэлэнгэ-Мөрөн



For and on behalf of
MyChina.biz Hong K
Завсраг
Director General





УИХ - гишүүн Ж.Бат-Эрдэнэ "Шинэ хөдөө" төслийн хүрээнд Мөрөн суманд үйл ажиллагаагаа явуулж буй "Мөрөн хүнс" ХХК тай танилцлаа. Жирийн малчин эмэгтэй өөрийн бүтээгдэхүүнээ өртөг шингээн зах зээлд эрэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаатай танилцав. Аймгийн ХХААГ-аас уг үйлдвэрийг олон улсын төслийн байгууллагатай холбон Мөрөн брендийг бий болгож байгаад талархаж байна.

Өж ё өжө:э
0 о,г



"Хэнтий Намрын баяр -2017" үзэсгэлэн худалдаанд сумынхаа шилдэг бренд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл эрхлэгчид болон хүнсний ногоо тариалагч нийт 45 хүний бүрэлдэхүүнтэй "Сум сурталчлах" арга хэмжээг зохион байгуулан оролцлоо.



П. Бямбадагва модон эдлэлийн төрөлд аймгийн шилдэг үйлдвэрлэгч болов.



Ж.Сэржмядаг сүү, цагаан идээ үйлдвэрлэлээрээ “Олны таашалд нийцсэн” бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр шалгарав.



“Мөрөн Хүнс” ХХК-н үйлдвэрлэсэн борц аймгийн шилдэг бүтээгдэхүүнээр шалгарав.



Мөрөн сум үйлдвэрлэлээрээ аймагтаа тэргүүлэн цом мөнгөн шагналаар шагнагдав.

Мөн Улаанбаатар хотноо жил болгон болдог “Намрын ногоон өдрүүд” арга хэмжээнд “Мөрөн хүнс” ХХК өөрийн бүтээгдэхүүнээр оролцож “орон нутгийн шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгч”-ээр шалгарсан төдийгүй БНХАУ-н Хөх хотын экспо үзэсгэлэн худалдаанд оролцсон.



Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдааны үеэр
ТҮҮХИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Мөрөн сумын нутагт нэн эртнээс хүн оршин амьдарч байсан ул мөр элбэг тохиолдож, эрдэмтдийн ном сударт гүнзгий тусгалаа олсон байдаг. Монголын түүхийн ном сударт нэр заагдаж тэмдэглэгдсэн алдартай дурсгалууд цөөнгүй бий.

БУМБАТЫН ХҮН ЧУЛУУН ХӨШӨӨ

Сумын төвөөс зүүн урагш 25 орчим км-т, Хэрэмийн баруун үзүүр, Бумбат гэх газар зэрэгцсэн хоёр чулуу бий. Эдгээр хөшөөний баруун талынх хүний нүүрний дүрс бүхий хөшөө юм.



БҮСИЙН ХИЙДИЙН ТУУРЬ:

Сумын төвөөс баруун урагш 40-д км-т, Хэрлэн голын хойд бие, Бүсийн уулын баруун хөндийд хуучны нэгэн хийдийн туурь бий. Үүнийг нутгийнхан Бүсийн хийдийн туурь хэмээн нэрлэдэг.



ДЭЛГЭР УУЛЫН ЭНГЭРИЙН БУЛШ:

Сумын төвийн хойд тал, Мөрөн голын зүүн хөндий, Дэлгэр уулын өвөр энгэрээр 10-д булш, хэдэн тахилын байгууламжуудын хамт оршино.



НАРИЙН ДЭЛИЙН ХИРГИСҮҮР, ТАМГАТАЙ ХӨШӨӨ:



Сумын төвөөс баруун хойш 3-4 км-т, Нарийн дэл уулийн наран талруу харсан энгэрт хэдэн хиргисүүр бий. Эдгээрийн хамгийн хойд талын хиргисүүрийн баруун талд нэгэн тамгатай хөшөө бий.





САЛБАР УУЛЫН БИЧИГТ ХАНАНГИЙН ИХ БАГА БИЧЭЭС:

Сумын төвөөс баруун тийш Чингис хотоос 30 гару й км –т оршдог салбар уулын ханан хадны бичээс их,бага хоёр хэсгээс бүрддэг.их бичээс нь гурван мөр 17 дүрс,бага бичээс нь нэг мөр 7 дүрс үсэг байдаг.Эрдэмтэн Х.Пэрлээ судлаад Салбарын бичигт ханагийн бичээс болон тамган дүрс зэргийг судлаад 10-11-р зууны Кидан улсын их бичигтэй холбон үзэж,уг дурсгалыг үлдээгчдийн удам нь бусад газрын хадны тамган дүрс хоцроогдистой нийтлэг гаралтай бөгөөд хожим монгол нэрийн дор ондоошин үлдсэн гэж урьдчилсан дүгнэлт хийжээ.





ХАТАН УУЛЫН ЭНГЭРИЙН БУЛШ:

Сумын төвөөс зүүн зүгт 7-8 орчим км-т, хтан уулын өвөрт эрт дээр үед эвдэгдсэн булш бий

ЧИНГИСИЙН ТУЛГЫН ЧУЛУУ:

Мөрөн сумын 2-р багийн нутагт, сумын төвөөс урагш 25 км-т, Зүүн хэрэмнээс урагш 2 км-т Хэрлэн голын хойд хөвөөнд голоос 5 орчим км-т гадаргуу дээрээ ямар нэгэн тамга, дүрслэлгүй боржин чулуун хөшөө байна. Энэхүү хөшөөг нутгийнхан Чингисийн зэлний чулуу хэмээн домоглон нэрлэдэг аж. Хөшөөнөөс баруун урагш 5 метр орчимд нэгэн эвдэрсэн тахилын онгон бололтой байгууламж байна.



ХУДАГТЫН АМНЫ БУУРАЛ УУЛЫН БУЛШ ТАХИЛЫН БАЙГУУЛАМЖ:

Мөрөн сумын 2-р багийн нутаг, сумын төвөөс баруун урагш 30 орчим км-т, Худагт хэмээн нэрлэдэг булгийн зүүн талд 1 дөрвөлжин булш, 1 дугуй хүрээтэй булш, 2 тахилын онгон байна.

Дөрвөлжин булшийг байгалийн энгийн чулуудаар дөрвөлжлөн намхан далан хийж дотор нь чулуугаар дүүргэж үйлдсэн байлаа. Энд орших дурсгалуудын анхны хэлбэр төрх бага хэмжээгээр алдагдсан байх.



Худагтын амны худагтын булгийн зүүн талд 2 тахилын онгон 2 хэсэг газар оршино. Тахилын онгоныг байгалийн хавтгай чулууг дөрвөлжилж голд чулуу дүүргэж үйлсэн байв. Тахилын онгонууд нь зэл чулуугүй юм.



ЭРДЭНЭ УУЛЫН БИЧЭЭС:Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт оршино.Анх 1979 онд нэрт эрдэмтэнх.Пэрлээ агсан Кидан бичгийн дурсгал байх боломжтой хэмээн мэдээлсэн.Түүнээс хойш лавшруулан судлах ажил хийгдээгүй.2005-2006 онд Монгол Японы хамтарсан Бичээс-2 төслийн хээрийн шинжилгээний анги нягтлан шалгаж,гэрэл зургыг нь нийтэлж судалгааны хүрээнд оруулсан байна.Энэ нь уулын оройн эсгийн хадан дээр хар бэхээр бичсэн ньнэг нь мөр бүхий 12 мөр, нөгөө нь 7 мөр бүхий 2 мөр кидан бичгийн дурсгал бөгөөд 11 дүгээр зууны үед бичигдсэн байх боломжтой.



Эрдэнэ уулын хятад бичээс



Эрдэнэ уулын кидан бичээс

ГЭЛЭН ХӨШӨӨ:

Чингис хотын нисэх ббудлын баруун урд 3 км зайтай,нутгийн ард олон гэлэн хөшөө гэж нэрлэдэг нэгэн хүн чулуун хөшөө бий.Хүрмэн чулуугар эр хүний дүрс оруулан хийсэн уг дүрс нь хавтгайдуу жинстэй,баруун гартаа ямар нэгэн сав барьсан бололтой,зүүн гараа өвдөг дээр тавин түшлэгтэй сандалд суусан байдалтайгаар дүрсэлжээ.пундад зууны эртэний жуулчдын тэмдэглэл хийгээд тухайн үеийн уран зургын дурсгалд нэн тодорхой дүрсэлсэн монголчуудын гээг үсийг хоёр чихний араар унжсан шибэлгэрийн хамт дүрсэлсэн монголчуудын гээг үсний ийм хэлбэр маягийг хүн чулуунд ийнхүү бүрэн бүтэн сийлэн үлдээсэн нь өөр хаанач үгүй юм.

Чихний араар унжсан шилбэргийг ганц салаа шошцоо хэлбэрээр гаргасан нь Чингис хааны хөрөг зургын үсний маягын ижил байгаа нь мөн онцлог,Цээжинд дээлийн энгэр заам дүрсэлсэнгүй,Бүс дүрслээгүй ч хоёр ташаанд хавтага байгаа нь бүстэй гэдгийг дам илэрхийлнэ.Доор нь хоёр богинохон хөл граган сандлын доорх тавцанд гишгүүлжээ.



УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ӨНДӨР ХААН УУЛ:

Өндөрхаан уул нь Мөрөн сумаас зүүн тийш 27 км,аймгийн төвөөс хойш 28 км-т оршдог.Далайн төвшнөөс дээш 2664 м өндөр тахилгат хайрхан.2012 оны УИХ-ын 53-р тогтоолоор Өндөрхаан уулыг Байгалын цогцолборт газар-ын ангиллаар Улсын тусгай хамгаалалтанд авсан.Өндөрхаан ууланд Буга,Бор гөрөөс,аргаль угалз зэрэг нэн ховор амьтадтай,хөх дэгд,аварга цорж,алтангагнуур,таван салаа,бамбай,нохой хошуу,тэхийн шээг,сөд өвс,чихэр өвс зэрэг эмийн ургамал,таана мангир,мойл,үрэл зэрэг жимс жимсгэнэ ургадаг.

Сумын төв мөр бичээс ийн зүүн хүйд тал,Мөрөн голын зүүн хөндий,Дэлгэр уулын өвөр энгэрээр 10-аад булш,хэдэн тахилын байгууламжын хамт оршино.





Өндөрхаан уул нь Мөрөн сумаас зүүн тийш 27км, аймгийн төвөөс хойш 28км-т оршдог. Далайн түвшнээс дээш 2664 м өндөр. Аймаг даяараа эртнээс нааш тахиж ирсэн их хайрхан.

БАРУУН,ЗҮҮН ХЭРЭМ:

Хятаны үеийн хот суурингийн дурсгал.

Хэнтий аймгийн Мөрөн сумын нутагт Зүүн, Баруун хэмээх зэрэгцээ хоёр хэрэм байдгийг археологич Х.Пэрлээ 1952-1953 оны хооронд малтан шинжилжээ.

Зүүн хэрэм. Зүүн хэрмийн хэмжээ, өмнө тал 420 м, баруун тал 502 м, хойт тал 510 м, зүүн тал 507 м. Баруун болон урд талдаа нэг, хойд болон зүүн талдаа тус бүр хоёр хаалга бүхий шороо дагтаршуулж хийсэн, гадуураа усан татаал шуудуу бүхий хэрэмтэй байжээ. Хэрлэн голоос ус татаж байсан шуудууны ор өмнө талд нь мэдэгддэг. Хэрмийн дээр болон дөрвөн буланд нийтдээ 28 харуулын цонж байсан байна. Хэрмийн одоогийн өндөр нь 1,5-2 м. өргөн нь 4-6 м. Хэрмийн өмнөд ба зүүн далдавчтай хаалгуудаас эхэлж төв дунд хүртэл үргэлжилсэн, хоёр талаараа хэрэмтэй, хоёр өргөн чөлөө гудамж байжээ.

Хэрмийн дотуур хэсэг барилгын ор туурь мэдэгддэгийн заримыг тусгай өндөр довжоон дээр барьсан байжээ. Эндхийн барилгыг барьсан байдал, орсон хэрэглэгдэхүүнээр нь хэд хувааж болно. Үүнд: Тусгай бяцхан хэрэмтэй, хөх тоосгон дээвэртэй барилгууд Тусгай хэрэмгүй, дээврийг нь ваарласан барилгууд Хэрэмгүй, дээврийн вааргүй барилгууд Эндхийн барилгуудыг ханз хэрэглэн халаадаг байжээ.

Нутгийн байгалийн нөхцөлд тохируулан аргал голдуу түлдэг, ур дарх хийдэг газарт илч сайтай залуу мод, битүү шатаасан хусны нүүрс хэрэглэж байжээ.

Малтлагаас үзэхэд энд ваар сав, төмөр эдлэл, барилгын хэрэглэгдэхүүн хийдэг хэдэн төрлийн үйлдвэр байсны хамгийн их хэмжээтэй нь ваар савны үйлдвэр юм.

Зүүн хэрмийн гол аж ахуй нь мал, тариалан хоёр байжээ. Малтлагаас малын яс их гарсан ба хонь үхрийнх олон, адуу тэмээнийх цөөвтөр байжээ. Гар тээрэм, үр тариа хадгалах том шавар ваарны үлдэц, тарианы чулуун уур, нүдүүр, анжисны төмөр хошууны хугархай, тариа цайруулах ингийн төмөр цөн, монгол аму будааны үлдвэр зэрэг зүйл гарсан байна. Мөн 1020-1031 оны хооронд цутгасан тайпин гэсэн хятад бичигтэй Хятан улсын хүрэл зоос олдсон нь тус хэрмийн он цагийг тогтооход чухал ач холбогдолтой олдвор болжээ. Иймээс хэрмийн холбогдох он цагийг Хятаны үе IX-XI зуунд холбогдуулан үздэг. Археологич Х.Пэрлээ 1952-1953 оны хооронд Зүүн хэрэмд 10 гаруй бага хэмжээний малтлага хийж хотын өмнөд хэсэгт ноёлох ангийнхан, хойд хэсэг дэх нүүдлийн маягтай сууцнуудад хамжлага сууж байсан хэмээн тодорхойлжээ.

Баруун хэрэм. Зүүн хэрмээс баруун тийш 2 км зайд Баруун хэрэм оршдог. Хэрмийн урд тал нь 826 м, баруун тал 803 м, хойт тал 825 м, зүүн тал 862 м урттай, одоогоор хэрмийн ханын зузаан 7-12 м, өндөр 1,5-3 м байна. Өмнөө хоёр, зүүн талдаа гурав, баруун ба хойт талдаа тус бүр нэжгээд хаалгатай байжээ. Хэрмийн дээр болон булангуудад цонж байсны үлдэгдэл овгорууд бий. Гадуураа мөн усан сувагтай. Үүнийг дундуур нь хэрмээр тасалж, заримд нь барилга байшин барьсан, зарим нь огт хоосон байжээ. Энэ хэрмийг Зүүн хэрмийн аж ахуйн газар, өөрөөр хэлбэл, одоо хоосон байгаа газруудад хүнсний ногоо тарьж, барилгатай хэсгүүдэд аму будаа агуулан байсан гэж судлаачид үзэж байна. Энэхүү хэрмийг судлаачид, 1012, 1015 оны үед Хэрлэнгийн дээд биеэр нутаглах аймгууд Хятан улсын эсрэг босч тэмцсэнийг кидан нар цэрэглэн дарж амьд үлдэгсдийг Хэрлэн голын эхэнд хоёр хот барьж суулгасан гэх мэдээтэй харьцуулан нягталж үүнийг мөн гэж үзсэн байна.



Баруун хэрэм хэмээх эртний хотын туурь



Зүүн хэрэм хэмээх эртний хотын туурь